

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/315
танай _____-ны № _____-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.ДАШДАВАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны эцсээр төсвийн санхүүжилтийг багасгаснаас ер төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 307.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагнал, төсвийн орлого бүрдүүлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 336.4 сая төгрөгийн 3 зөрчлийг илрүүлж зөвлөмж өглөө.

Бусад асуудлын хэсэг

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Цэцэрлэг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээнд 5 зорилт 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 74.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,801,720.4	1,598,429.0
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,409,999.2	1,093,753.3
3	1.1.3 АВЛАГА	141,239.6	166,850.1
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	250,481.6	337,825.6
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,283,887.9	7,324,106.8
6	1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	111,955.9	148,846.6
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,171,932.1	7,175,260.2
8	1.2.2.02 Биет хөрөнгө	5,525,151.1	6,357,528.2
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	646,781.0	817,732.0
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,085,608.4	8,921,919.8
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,615.7	345,871.5
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,615.7	345,871.5
13	2.1.1.03 Өглөг	38,615.7	345,871.5
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,046,992.6	8,576,048.3
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	8,046,992.7	8,576,048.3
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	1,105,063.2	1,105,063.2
17	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,586,191.8	4,841,469.4
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	1,864,411.8	2,135,689.9
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	491,325.8	491,325.8
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,085,608.4	8,921,919.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,644,310.2	3,063,118.5
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,050,716.8	1,002,595.9
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	886,493.9	715,186.1
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	886,493.9	715,186.1
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	32,867.1	92,506.6
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	131,355.8	194,903.2
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-462,646.8	2,060,522.6
8	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	1,250.0	0.0
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	980,667.6
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,056,240.1	0.0

11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,638,411.5	2,739,828.6
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,638,411.5	2,739,828.6
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,580,669.5	2,714,343.0
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	903,846.7	1,011,189.3
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,694.5	124,465.6
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,728.0	134,109.9
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	856,718.9	412,789.3
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	66,320.2	97,403.3
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	6,623.0	4,633.0
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,825.8	184,838.6
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	369,912.5	744,914.1
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,742.0	25,485.6
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,005,898.7	323,289.9
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,011.9	52,011.8
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-25,011.9	-52,011.8
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	980,886.8	271,287.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,214,992.4	3,768,555.0
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,050,716.8	1,002,596.0
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	886,493.9	715,186.1
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	32,867.1	92,506.6
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	131,355.8	194,903.2
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,821.3	14,374.7
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	45,788.9	63,027.7
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,745.6	117,500.9
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,035.4	2,765,959.01
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	106,785.4	87,968.4
11	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	1,250.0	0.0
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	980,667.6
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,697,323.1
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,056,240.1	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,967,612.2	2,063,596.3
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,967,612.2	2,063,596.3
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,909,870.3	2,038,110.7

18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,086,813.0	1,275,963.4
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,624.9	124,639.8
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,345.1	193,967.6
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	212,777.8	143,446.3
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	3,900.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	70,889.9	97,703.3
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	6,623.0	4,633.0
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,639.7	110,656.6
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	103,156.8	83,200.5
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,742.0	25,485.6
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,247,380.13	1,704,958.79
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,342,592.8	1,940,869.7
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,342,592.8	1,940,869.7
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,342,592.8	1,940,869.7
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,342,592.8	-1,940,869.7
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,000.0	80,000.0
34	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	335.0
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-35,000.0	-80,335.0
36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	869,787.3	-316,245.9
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	540,211.9	1,409,999.2
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,409,999.2	1,093,753.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,205.9	6,767,205.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	144.0	144.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,767,349.9	6,767,349.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,144.0	-2,144.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	300,900.0	300,900.0
6	Тайлант үеийн үр дүн	980,886.8	980,886.8
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,046,992.6	8,046,992.6
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,046,992.6	8,046,992.6

10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,046,992.65	8,046,992.65
11	Өмчид гарсан өөрчлөлт	257,777.6	257,777.6
12	Тайлант үеийн үр дүн	271,278.1	271,278.1
13	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,576,048.3	8,576,048.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,514,586.2	5,458,406.9	(56,179.3)	99.0
11	Татварын орлого	949,499.6	1,002,596.0	53,096.4	105.6
110	Орлогын албан татвар	687,356.7	715,186.1	27,829.4	104.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	687,356.7	715,186.1	27,829.4	104.0
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	521,536.7	534,903.0	13,366.3	102.6
110002	Үйл ажиллагааны орлого	10,000.0	14,509.1	4,509.1	145.1
110003	Хөрөнгийн орлого	69,000.0	83,366.5	14,366.5	120.8
110004	Хөрөнгө борлуулсны орлого	1,820.0	3,447.2	1,627.2	189.4
110008	Шууд бус орлого	85,000.0	78,960.3	(6,039.7)	92.9
113	Хөрөнгийн албан татвар	103,000.0	92,506.6	(10,493.4)	89.8
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	14,700.0	10,753.3	(3,946.7)	73.2
113002	Бууны албан татвар	3,300.0	3,207.0	(93.0)	97.2
113004	Малд ногдуулах албан татвар	85,000.0	78,546.3	(6,453.7)	92.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	159,142.9	194,903.2	35,760.3	122.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,760.0	14,374.7	2,614.7	122.2
118001	Улсын тэмдэгийн хураамж	6,000.0	10,589.7	4,589.7	176.5
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	800.0	870.0	70.0	108.8
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,960.0	2,915.0	(2,045.0)	58.8
1181	Газрын төлбөр	6,900.0	63,027.7	56,127.7	913.4
118101	Газрын төлбөр	6,900.0	11,853.7	4,953.7	171.8
118102	Дуудлага худалдаа	-	51,174.0	51,174.0	
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	140,482.9	117,500.9	(22,982.0)	83.6
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	68,707.9	49,763.8	(18,944.1)	72.4
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	67,560.0	66,446.0	(1,114.0)	98.4
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	330.0	586.1	256.1	177.6
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	3,885.0	705.0	(3,180.0)	18.1
12	Татварын бус орлого	4,565,086.6	4,455,810.9	(109,275.7)	97.6
120	Нийтлэг татварын бус орлого	92,017.7	33,692.5	(58,325.2)	36.6
120003	Торгуулийн орлого	3,600.0	12,605.1	9,005.1	350.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2,050.6	-	(2,050.6)	0.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	86,367.1	21,087.4	(65,279.7)	24.4
122	Тусламжийн орлого	2,716,507.5	2,724,795.3	8,287.8	100.3
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	902,754.5	902,754.5	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	1,813,753.0	1,822,040.8	8,287.8	100.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,756,561.4	1,697,323.1	(59,238.3)	96.6
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,756,561.4	1,697,323.1	(59,238.3)	96.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,844,651.2	3,966,170.8	-878,480.4	81.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,217,467.2	2,013,319.5	-204,147.7	90.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,193,043.3	1,991,833.9	(201,209.4)	90.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,059,567.2	1,009,850.8	(49,716.4)	95.3
210101	Үндсэн цалин	513,798.0	507,253.8	(6,544.2)	98.7
210102	Нэмэгдэл	423,103.6	410,323.7	(12,779.9)	97.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,360.0	34,595.8	(1,764.2)	95.1

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	86,305.6	57,677.4	(28,628.2)	66.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,836.2	124,639.8	(7,196.4)	94.5
210201	Тэтгэврийн даатгал	89,648.5	86,389.8	(3,258.7)	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	10,546.9	10,133.7	(413.2)	96.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,273.5	5,058.9	(214.6)	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	5,273.5	4,737.8	(535.7)	89.8
210205	Эрүүл мэндийн даатгал	21,093.8	18,319.7	(2,774.1)	86.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	633,875.9	550,969.6	(82,906.3)	86.9
210301	Гэрэл, цахилгаан	58,357.5	49,529.2	(8,828.3)	84.9
210302	Түлш, халаалт	539,887.2	473,441.2	(66,446.0)	87.7
210303	Цэвэр, бохир ус	35,631.2	27,999.2	(7,632.0)	78.6
2104	Хангамж, бараа материалын зардал	76,185.5	63,058.7	(13,126.8)	82.8
210401	Бичиг хэрэг	6,300.0	3,744.0	(2,556.0)	59.4
210402	Тээвэр, шатахуун	45,800.0	41,164.8	(4,635.2)	89.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,700.0	3,525.0	(1,175.0)	75.0
210404	Ном, хэвлэл	450.0	-	(450.0)	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,464.0	522.0	(1,942.0)	21.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,471.5	14,102.8	(2,368.7)	85.6
2105	Нормативт зардал	3,900.0	3,900.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,900.0	3,900.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	131,796.6	112,491.7	(19,304.9)	85.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,350.0	13,540.4	(2,809.6)	82.8
210604	Урсгал засвар	115,446.6	98,951.3	(16,495.3)	85.7
2107	Томилолт, зочны зардал	7,000.0	4,633.0	(2,367.0)	66.2
210702	Дотоод албан томилолт	7,000.0	4,633.0	(2,367.0)	66.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,371.6	44,189.8	(16,181.8)	73.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,910.5	40,677.7	(15,232.8)	72.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209.6	1,209.6	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	190.0	120.0	(70.0)	63.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373.5	273.4	(100.1)	73.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.0	88.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100.0	979.0	(121.0)	89.0
210807	Газрын төлбөр	1,500.0	842.0	(658.0)	56.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,510.3	78,100.6	(10,409.8)	88.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,010.3	73,225.1	(7,785.3)	90.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,500.0	4,875.5	(2,624.5)	65.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,423.9	21,485.6	(2,938.3)	88.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,423.9	21,485.6	(2,938.3)	88.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,023.9	20,023.9	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,400.0	1,461.7	(2,938.3)	33.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,540,816.9	1,872,851.3	(667,965.6)	73.7
223001	Бусад хөрөнгө	2,540,816.9	1,872,851.3	(667,965.6)	73.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	86,367.1	80,000.0	(6,367.1)	92.6
230001	Эргэж төлөгдөх зээл	86,367.1	80,000.0	(6,367.1)	92.6
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	669,935.0	(595,400.9)	(1,265,335.9)	-88.9
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(669,935.0)	595,400.9	1,265,335.9	-88.9
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(669,935.0)	595,400.9	1,265,335.9	-88.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,393,770.4	1,393,770.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,072,065.8	1,072,065.8	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөг)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 он	2025 он	7. Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	100,349.0	77,913.1	(22,435.9)
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		77,913.1	77,913.1
122	Тусламжийн орлого		77,913.1	77,913.1
1221	Хандив тусламж /дотоод/		77,913.1	77,913.1
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,349.0	77,913.1	(22,435.9)
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,920.0		(3,920.0)
350013	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,500.0		(5,500.0)
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,870.0	58,601.1	(16,268.9)
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,059.0	19,312.0	3,253.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,349.0	69,813.1	(30,535.9)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,349.0	21,013.1	(79,335.9)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,662.0	17,013.1	(79,648.9)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,307.5	1,338.6	(48,968.9)
210104	Урамшуулал	50,307.5	1,338.6	(48,968.9)
2104	Хангамж, бараа материалын зардал	14,553.5	10,574.5	(3,978.9)
210401	Бичиг хэрэг		358.0	358.0
210402	Тээвэр, шатахуун	10,483.5	5,390.5	(5,092.9)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		699.5	699.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,070.0	4,126.5	56.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,582.0	-	(3,582.0)
210604	Урсгал засвар	3,582.0	-	(3,582.0)
2107	Томилолт, зочны зардал	1,134.0	-	(1,134.0)
210702	Дотоод албан томилолт	1,134.0	-	(1,134.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,720.0	-	(18,720.0)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,720.0	-	(18,720.0)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,365.0	5,100.0	(3,265.0)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,780.0	-	(7,780.0)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	585.0	5,100.0	4,515.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,687.0	4,000.0	313.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,687.0	4,000.0	313.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,687.0	4,000.0	313.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		48,800.0	48,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр		48,800.0	48,800.0
223001	Бусад хөрөнгө		48,800.0	48,800.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		8,100.0	8,100.0
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(8,100.0)	(8,100.0)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сан, Тэсийн илч ХХК-ийн нийт 5 санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн хүрээнд гарсан мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэснээс ЗДТГ, Тэсийн илч ХХК-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар Цэцэрлэг сумын ЗДТГ “Өөрчлөлтгүй”, Тэсийн илч ХХК “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудитын 3,081.7 сая төгрөгийн 9 зөрчил, нийцлийн аудитын 1 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилд үндэслэн 2.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,033.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 45.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн орлого бүрдүүлэлт, авлагын данстай холбоотой санхүүгийн тайлангийн 336.4 сая төгрөгийн 2 зөрчил, нийцлийн аудитын 1 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлж байна.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн 42.9 сая төгрөгийн 6 иргэн, аж ахуйн нэгжийн зээл хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын 3.4.11 “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хугацаа хэтэрсэн зээлийг эргэн төлүүлэх талаар арга хэмжээг зохион байгуулах

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Илрүүлэлт:

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 293.5 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг ОНХС, ХХС-ийн хөрөнгийн зарцуулалт, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагааг хянаж үзэхэд ХХС-ийн 80.0 сая төгрөгийн зээл олгосон мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:... 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр,” заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төвлөрүүлэн захирагч												
Хоршоо хөгжүүлэх сангийн 42.9 сая төгрөгийн 6 иргэн, аж ахуйн нэгжийн зээл хугацаа хэтэрсэн байна	1	42.9					1	42.9				
Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 293.5 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.	1	293.5					1	293.5				
Дүн	2	336.4					2	336.4				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар	2	6.1	1	2.6							1	3.5
Тэсийн илч ХХК	7	3,075.6							4	3,033.2	3	42.4
Дүн	9	3,081.7	1	2.6					4	3,033.2	4	45.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
ХХС-ийн 80.0 сая төгрөгийн зээл олгосон мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна	1							1
Дүн	1							1
Харьяа байгууллагуудын зөрчил								
Тэсийн илч ХХК								1
Дүн	1							1